



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 4/220

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө шинэчлэн
батлах тухай

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 4.4 дүгээр хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13.1.4 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай" 2013 оны А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхөд зориулсан хос хэлний сургалтын бодлого, агуулга, хөтөлбөр боловсруулж, бэлтгэл ханган 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

4. Энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, чанартай хэрэгжүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.


5. Үндэстний цөөнхөд зориулсан хос хэлний сургалтын бодлого, агуулга, хөтөлбөр, сурах бичгийг 2015-2016 оны хичээлийн жилд багтаан боловсруулж, бэлтгэл хангахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/, Боловсролын хүрээлэн /Э.Энхпүрэв/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай" 2013 оны А/311 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн I-XII ангийн сургалтын төлөвлөгөөний VI-IX ангид хамаарах хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2014 оны А/488 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Л.ГАНТӨМӨР

09 00782



Бага боловсролын сургалтын төлөвлөгөө

Хичээл		I анги	II анги	III анги	IV анги	V анги	Нийт цаг	
Судлагдахуун	Бэлтгэл хөтөлбөр	60					60	
	Монгол хэл	203	224	231	231	231	1120	
	Математик	116	160	165	165	165	771	
	Хүн ба орчин	87	96	99			282	
	Хүн ба нийгэм				33	66	99	
	Хүн ба байгаль				66	66	132	
	Урлаг	Дүрслэх урлаг технологи	58	64	66	66	66	320
		Хөгжим	58	64	66	66	33	287
		Биеийн тамир	58	64	66	66	66	320
		Англи хэл					99	99
	Судлагдахууны нийт цаг		640	672	693	693	792	3490
Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	Иргэний боловсрол (ёс суртахуун)	29	32	33	33	33	160	
	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	58	32	33	33	33	189	
	Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа				33	33	66	
	Үйл ажиллагааны нийт цаг	87	64	66	99	99	415	
Жилийн нийт цаг		727	736	759	792	891	3905	
Долоо хоногийн дундаж нийт ачаалал		22.7	23.0	23.0	24.0	27.0		
Өдрийн ачаалал		4.5	4.6	4.6	4.8	5.4		

Тайлбар:

1. Хичээлийн жилд I, II анги 32 долоо хоног, III-V анги 33 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна.
2. Нэгдүгээр ангийн "Бэлтгэл" хөтөлбөр нь суралцагчдыг сургуулийн амьдрал, сурах үйл ажиллагаанд бэлтгэхэд чиглэсэн нэгдмэл агуулгатай үйл ажиллагаа бөгөөд хичээлийн жилийн эхэнд хэрэгжүүлнэ.
3. Орон нутаг, сургуулийн онцлог болон багшлах хүний нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн суралцагчийн хөгжлийн дэмжихүйцээр тухайн анги, боловсролын түвшинд уян хатан байхаар сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
4. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно. Иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагааг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.
5. Иргэний боловсрол нь сурагчдыг үндэсний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг дээдлэн хайрладаг, хамтач энэрэнгүй, үнэнч шударга, эх оронч, ёс суртахуунлаг иргэнийг төлөвшүүлэхэд чиглэнэ.
6. Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2015 оны 06 дугаар сарын 10 өдрийн
дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Хичээл, судлагдахуун		VI анги	VII анги	VIII анги	IX анги	Дүн
1	Монгол хэл, бичиг	Монгол хэл	105	70	70	70	315
		Уран зохиол	70	70	70	70	280
		Үндэсний бичиг	70 ¹	70	70	70	280
2	Математик		175	140	140	140	595
3	Мэдээллийн технологи		35	35	35	35	140
4	Байгалийн ухаан	Физик	35	70	70	70	245
		Биологи	35	70	70	70	245
		Хими	35	70	70	70	245
		Газар зүй		35	35	35	105
5	Нийгмийн ухаан	Түүх	35	70	70	70	245
		Нийгэм судлал		35	35	35	105
6	Урлаг	Дүрслэх урлаг	35	35	35		105
		Хөгжим	35	35	35	35	140
7	Дизайн технологи	Зураг зүй	70	70	70	70	280
		Технологи					
8	Биеийн тамир, эрүүл мэнд		70	70	70	70	280
9	Гадаад хэл	Англи хэл	105	105	105	105	420
		Орос хэл		70	70	105	245
Дүн			910	1120	1120	1120	4270
10	Сургалт дэмжих үйл ажиллагаа	Иргэний боловсрол	35	35	35	35	140
		Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа	35	35	35	35	140
		Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	35	35	35	35	140
Дүн			105	105	105	105	420
Хичээлийн жилийн нийт цаг			1015	1225	1225	1225	4690
Долоо хоногийн цаг			29.0	35.0	35.0	35.0	
Өдрийн цаг			5.8	7.0	7.0	7.0	

1. Дунд анги хичээлийн жилд 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
2. Сургалтын төлөвлөгөөг заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн тухайн анги, нийт ангийн түвшинд уян хатан байхаар хэрэгжүүлнэ.
3. Сургууль өдрийн 5-7 цагт 4-өөс доош хичээлийг багцлан зохион байгуулж болно.
4. Сургалт дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно.
5. ¹ - 6 дугаар ангийн үндэсний бичгийн 70 цагийн хичээлийг зөвхөн 2015-2016 оны хичээлийн жилд 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн тус хичээлийн жил дуусах хүртлэх хугацаанд зохион байгуулна.
6. Сургалт дэмжих үйл ажиллагааг аль ч хичээл, судлагдахууныг зохион байгуулж буй багш удирдаж болно.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

┌ Сургалтын төлөвлөгөө батлах тухай ┐

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид 2017-2018 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх бэлтгэл хангах, сургуулийн удирдлага, багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулахыг Боловсролын бодлогын газар /Д.Эрдэнэчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /М.Мөнхбаатар/, Боловсролын хүрээлэн /М.Итгэл/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /А.Туяа/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2015 оны А/320 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө батлах тухай" 2016 оны А/103 дугаар тушаал, "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/275 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө"-ний XI, XII ангид хамаарах хэсэг, гуравдугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн XI, XII ангийн сургалтын төлөвлөгөө"-г тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Г.ЧУЛУУНБААТАР

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2017 оны 7 дугаар сарын 4 өдрийн
А/161 дугаар тушаалын хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө

Хичээл		X анги	XI анги	XII анги
1. Заавал судлах				
1	Монгол хэл, бичиг	105	70	70
2	Уран зохиол	35	35	35
3	Математик	105	105	105
4	Физик	70	70	70
5	Хими	70	70	70
6	Биологи	70	70	70
7	Газар зүй	70	70	70
8	Монголын түүх	35	35	35
9	Нийгэм судлал	70	70	70
10	Англи хэл/Орос хэл	105	105	105
11	Биеийн тамир, эрүүл мэнд	70	70	70
12	Дизайн/зураг зүй, технологи	70	70	70
13	Мэдээллийн технологи	35	35	35
Заавал судлах нийт цаг		910	875	875
2. Сонгон судлах				
Хэл	Монгол хэл, бичиг	245	280	280
	Уран зохиол			
	Англи хэл			
	Орос хэл			
Математик				
Байгалийн ухаан	Биологи			
	Хими			
	Физик			
Нийгмийн ухаан	Газар зүй			
	Түүх			
	Нийгэм судлал			
	Бизнес судлал			
Дизайн технологи				
Мэдээллийн технологи				
3. Сургууль зохицуулах цаг		70	70	70
Жилийн нийт цаг		1225	1225	1225

Тайлбар:

- Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна. Сургууль 80 минутаар хичээллэх зохицуулалт хийж болно.
- Сургууль зохицуулах цагт амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, урлаг, спортын дугуйлан, секц зохион байгуулна.
- Сурагч заавал судлах англи, орос хэлний аль нэгийг судална.
- Сурагч X ангид 4 хичээлийг 7 хоногт тус бүр 1-2 цагаар, XI, XII ангид 3 хичээлийг 7 хоногт тус бүр 2-3 цагаар сонгон судална.
- Заавал судлах хэсгийн биеийн тамир, эрүүл мэнд, дизайн/зураг зүй, технологи, мэдээллийн технологи хичээлийг Боловсролын хүрээлэнгээс боловсруулсан агуулгын хүрээ, суралцахуйн удирдамжийн дагуу зохион байгуулна.
- X-XI анги Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/277 дугаар тушаалаар баталсан "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-өөр, XII анги "Монголын түүх"-ээс бусад судлагдахууныг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 12 дугаар ангийн сургалтын хөтөлбөр"-өөр хичээллэнэ.
- XII ангийн "Монголын түүх"-ийн хичээлийг Боловсролын хүрээлэнгээс боловсруулсан суралцахуйн удирдамжаар зохион байгуулна.